

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй ©

АМАРТҮВШИНГИЙН ЦОЛМОНТУЯА

**НИЙСЛЭЛИЙН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМЧ,
СУВИЛАГЧДЫН ДУНДАХ СҮРЬЕЭГИЙН ХАЛДВАРЛАЛТ,
ӨВЧЛӨЛИЙН СУДАЛГАА**

E720100 Нийгмийн эрүүл мэнд

Нийгмийн эрүүл мэндийн магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар хот

2013 он

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

АМАРТҮВШИНГИЙН ЦОЛМОНТУЯА

**НИЙСЛЭЛИЙН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭМЧ,
СУВИЛАГЧДЫН ДУНДАХ СҮРЬЕЭГИЙН ХАЛДВАРЛАЛТ,
ӨВЧЛӨЛИЙН СУДАЛГАА**

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

АУ-ны доктор, дэд профессор Д.Даваалхам

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх:

АУ-ны доктор, дэд профессор Б.Баярмагнай

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

АУ-ны доктор Н.Хоролсүрэн

Улаанбаатар хот

2013 он

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1. Судалгааны ажлын үндэслэл

ДЭМБ-ын судалгаагаар Номхон Далайн Баруун Бүсэд багтдаг сүрьеэгийн өвчлөл өндөртэй 7 орны 3 дугаарт Монгол улс орж байна. Сүрьеэ өвчин манай орны нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг бөгөөд бүртгэгдсэн нийт халдварт өвчний дотор бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ) болон вирүст гепатитын өвчлөлийн дараа бүртгэгдэж, нас баралтын түвшнээрээ халдварт өвчний дотор тэргүүлэх байр эзэлж байна.¹

Эрүүл мэндийн байгууллага нь сүрьеэгийн халдвар тархах эрсдэл бүхий орчин юм. Гэхдээ энэ нь тухайн эрүүл мэндийн байгууллагын төрөл, хүн амын дундах сүрьеэгийн тархалтын түвшин, үйлчилгээ үзүүлдэг өвчтөн, ЭМА-ны төрөл, ЭМА-ны ажиллах байр, нөхцөл, халдвар хяналтын хөтөлбөр хир зэрэг амжилттай хэрэгжиж байгаа зэргээс шалтгаална. Сүрьеэтэй өвчтөн оношлогдохоос өмнө эмнэлгийн тусламж үйлчилгээ авдаг хэсэг буюу өрхийн эрүүл мэндийн төв, эсвэл халдвар ялгаруулж буй өвчтөнг оношлох, эмчлэх үйл ажиллагаа хийдэг тасаг нэгжид халдвар тархах эрсдэл өндөр байдаг.²

АНУ-ын Өвчний Хяналт, Сэргийлэлтийн Төвийн тоо баримтаар тус улсад сүүлийн жилүүдэд сүрьеэгийн дэгдэлт эмнэлгээс шалтгаалсан халдвар байдлаар бүртгэгдсэний дотор өвчтөн ба ЭМА-ууд олон эмэнд дасалтай сүрьеэ (ОЭДС)-ээр өвчилсөн тохиолдол нилээн байна. Эдгээр өвчтөний олонхи, зарим ЭМА урьд нь ХДХВ-ийн халдвар авсан байсан учир шинээр авсан халдвар нь маш хурдан өвчин үүсэхэд нөлөөлсөн. Энэ дэгдэлтийн үед гарсан нас баралтын хувь өндөр (43%-93%), оношлогдоод нас барах хүртэлх хугацаа богино (4-16 долоо хоног) байсан байна.

Дэгдэлт гарахад нөлөөлсөн хүчин зүйлсэд сүрьеэгийн оношлогооны хожимдол, эмийн даслыг тодорхойлоход гарсан хожимдол, эмчилгээг оройтож эхэлснээс болж халдвараа удаан хугацаагаар ялгаруулсан, сүрьеэтэй өвчтөнг тусгаарлах ажил хангалтгүй, тусгаарлах өрөөний агааржуулалт хангалтгүй, ханиалгалтыг нэмэгдүүлдэг ажилбарыг хийхдээ хамгаалах хэрэгсэл ашигладаггүй, мөн эмч ажилчдыг хамгаалах хэрэгсэл дутагдалтай байсан гэж үзсэн байна.

ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан мэдээгээр 2007-2009 онд манай улсад шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн өвчлөлийн байдалд дүгнэлт хийхэд эрүүл мэндийн ажилтнаас 111 хүн өвчилсөн нь нийт өвчлөлийн 1.1%-ийг эзэлж байна. Ялангуяа сум, өрхийн эмч, эрүүл мэндийн ажилтан, шинжээч эмч, мэс засал, шүд, сүрьеэгийн эмч мэргэжилтнүүд давамгайлж өвчилсөн байна.

Иймд эрүүл мэндийн байгууллагад сүрьеэгийн халдвар тархах нөхцөл, эрүүл мэндийн ажилтны дундах сүрьеэгийн халдварлалт, өвчлөл, нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг судалж, эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын арга хэмжээг сайжруулах, эрүүл мэндийн ажилтныг хамгаалах, дэмжих талаар зөвлөмж боловсруулах шаардлагатай байна.

1.2. Судалгааны ажлын зорилго

Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчдын дундах сүрьеэгийн халдварлалт, өвчлөлийн түвшинг судлах зорилготой.

1.3. Судалгааны ажлын зорилт

1. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарын дундах сүрьеэгийн халдварлалтыг судлах
2. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарын дундах өвчлөлийн түвшинг тодорхойлох

1.4. Судалгааны ажлын шинэлэг тал

Монгол улсын эрүүл мэндийн салбарын анхан шатанд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний дундах сүрьеэгийн халдварлалт, өвчлөлийг анх удаа тодорхойлж буйгаараа шинэлэг болсон.

1.5. Судалгааны ажлын практик ач холбогдол

Эмнэлгийн мэргэжилтний дундах сүрьеэгийн халдварлалтыг тогтоож, цаашид эрүүл мэндийн байгууллагын сүрьеэгийн халдвар хяналтыг сайжруулах, эрүүл мэндийн ажилтныг хамгаалах, дэмжих, ажлын байрны аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай нотолгоог бүрдүүлж байгаад ажлын практик ач холбогдол оршино.

1.6. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ

1. Судалгааны ажлын сэдэв аргачлалыг ЭМШУИС-ийн НЭМС-ийн Эпидемиологи Биостатистикийн тэнхимийн 2012 оны 2 сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. (Протокол №12/01/7)
2. ЭМШУИС-ийн Биоанагаахын ёс зүйн салбар хорооны хурлаар судалгааг явуулах биоанагаахын ёс зүйн зөвшөөрөл авсан. Био ёс зүйн хяналтын салбар хорооны хурлын тэмдэглэл 2012 оны 3 сарын 16 Протокол №24/1А
3. Судалгааны ажлын явцыг ЭМШУИС-ийн НЭМС-ийн Эпидемиологи Биостатистикийн тэнхимийн 2013.03.11-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. (Протокол №13/3/1)
4. ЭМШУИС-ийн Биоанагаахын ёс зүйн салбар хорооны хурлаар судалгааг явуулсан биоанагаахын ёс зүйн дүгнэлт гаргуулсан. Анагаах Ухааны ёс зүйн хяналтын салбар хорооны хурлын тэмдэглэл 2013 оны 4 сарын 16. Протокол №13-10/2А

1.7. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГ ХЭВЛЭН НИЙТЛҮҮЛСЭН БАЙДАЛ

Өгүүлэл

1. Цолмонтуяа А, Наранзул Д, Даваалхам Д. Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчдын сүрьеэгийн халдварлалт, өвчлөлийн судалгаа. “Халдварт Өвчин Судлалын Монголын сэтгүүл”, 2013; 4:13-15

2. Цолмонтуяа А, Наранзул Д, Даваалхам Д. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатанд ажиллагсдын сүрьеэгийн халдварт өртөлтийн байдал “Онош” Анагаах ухааны сэтгүүл, 2013;3:34-38

Илтгэл

1. Цолмонтуяа А, Солонго Б, Баярмагнай Б, Оюунгоо Б, Оюунцэцэг С Сүрьеэгийн халдвар хамгааллын талаарх сургалтын хэрэгцээ. Анагаах ухааны боловсрол судлал, сувилахуйн ухааны салбар. Эрдмийн чуулган-54. Х.144-148

2. Tsolmontuya A, Solongo B, Bayrmagnai B, Oyungoo B, Oyuntsetseg S. Training needs of tuberculosis infection control. “Current advances in medical education” international conference dedicated to the 70th anniversary of health science university of Mongolia. 2012;124

1.8. Судалгааны ажлын ёс зүй

Судалгааны ажлын арга, аргачлалыг ЭМШУИС-ийн Био-Анагаахын Ёс зүйн Хяналтын Хороогоор хэлэлцүүлж ёс зүйн зөвшөөрөл авсан.

Судалгаанд оролцох эмч, сувилагчид судалгааны зорилго, ач холбогдолыг сайтар ойлгуулж, ярилцсаны дараа таниулсан зөвшөөрлийн хуудсан дээр гарын үсэг зуруулан баталгаажуулсны үндсэн дээр судалгаанд хамруулсан.

Асуумж болон туберкулины сорил, цээжний рентген шинжилгээнд хамрагдах эмч, сувилагчид судалгааны ажлын зорилго, ач холбогдлыг сайтар ойлгуулж, ярилцсаны дараа таниулсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулж судалгаанд хамруулсан.

Хэрэв асуумж судалгаагаар сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэг илэрч, цээжний рентген зурагт өөрчлөлттэй гарсан тохиолдолд судалгаанд оролцогчийн зөвшөөрлөөр онош тодруулах зорилгоор цэрний шинжилгээ авсан.

Судалгааны явцад биоанагаахын судалгааны ёс зүйн үндсэн зарчмуудыг чанд баримтлан ажилласан.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
БҮЛЭГ 1. УДИРТГАЛ	
1.1. Судалгааны ажлын үндэслэл	8-9
1.2. Судалгааны ажлын зорилго	9
1.3. Судалгааны ажлын зорилт	9
1.4. Судалгааны ажлын шинэлэг тал	9
1.5. Судалгааны ажлын практик ач холбогдол	9
1.6. Судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал	10
1.7. Судалгааны үр дүнг хэвлэн нийтлүүлсэн байдал	11
1.8. Судалгааны ажлын ёс зүй	11
БҮЛЭГ 2. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ	
2.1. Сүрьеэ өвчин	12
2.2. Сүрьеэ өвчний тархалт дэлхий дахинд	13-14
2.3. Сүрьеэ өвчний тархалт манай оронд	14-16
2.4. Mycobacterium tuberculosis-ийн халдварлалт	16-19
2.5. БЦЖ вакцины талаар	19
2.6. Сүрьеэ өвчний оношлогоо, илрүүлэлт	19-22
2.7. Эрүүл мэндийн ажилтны сүрьеэгийн халдварт өртөх эрсдэл	23-24
2.8. Манай улсад ЭМА-ны дунд сүрьеэгийн өвчлөл бүртгэгдсэн байдал	25
БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ	
3.1. Судалгааны загвар	26

3.2.	Судалгааны хамрах хүрээ ба түүвэр	26-27
3.3.	Судалгаанд оруулах шалгуур	28
3.4.	Судалгааны материал цуглуулсан аргууд	28
3.5.	Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн	
3.5.1.	Эмч, сувилагчийн дундах сүрьеэгийн халдварлалтыг тогтоох	28-31
3.5.2.	Сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх, оношлох, эмчлэх	32-35
3.6.	Мэдээ, мэдээллийн статистик боловсруулалт	36
БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН		
4.1.	Судалгаанд хамрагдсан хүн амын ерөнхий шинж байдал	37-41
4.2.	Эмч, сувилагчийн дундах сүрьеэгийн халдварын тархалт	42-49
4.3.	Эмч, сувилагчийн дундах сүрьеэгийн өвчлөл	49-50
БҮЛЭГ 5. ХЭЛЦЭМЖ		51-57
БҮЛЭГ 6. СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ		58
БҮЛЭГ 7. ЗӨВЛӨМЖ		59
НОМ ЗҮЙ		
ТАЛАРХАЛ		
ХАВСРАЛТ		

НОМ ЗҮЙ

1. Наранбат Н. Сүрьеэтэй тэмцэх ажлыг эрчимжүүлье. Сүрьеэгийн үндэсний V семинар; Улаанбаатар. 2004. х.52.
2. Наранзул Д. Буянхишиг Б. Отгонцэцэг Д. Сүрьеэгийн халдвар хяналтын гарын авлага; Улаанбаатар, 2011х.13
3. Jose A Caminero Luna. A Tuberculosis Guide for Specialist Physicians. 2003
4. ДЭМБ. Дэлхийн сүрьеэгийн тайлан. 2011
5. Juan CP, Sylvia, Viviana R.Tuberculosis 2007. [e-book]
6. Сүрьеэтэй тэмцэх сэргийлэх үндэсний стратеги 2010-2015. Улаанбаатар. 2009 х.4
7. Management of tuberculosis Training for Health facility Staff. WHO. Second edition. Switzerland. 2010
8. WHO Fact sheet №104, March 2012
9. Уранчимэг З, Болор Р, Оюунчимэг А, Дариймаа Б. Олон эмийн дасалтай сүрьеэтэй эмчлүүлэгчдийн тулгамдсан асуудлууд. Халдварт Өвчин Судлалын Монголын Сэтгүүл, 2010; 6(37)
10. Global tuberculosis control WHO, 2011
11. Sudre, P., G. T. Dam, and A. Kochi. 1992. Tuberculosis: a global overview of the situation today. Bull. World Health Org. 70:149-159.
12. НДББ-ийн сүрьеэгийн талаарх тайлан. ДЭМБ, 2008
13. Дэлхийн сүрьеэгийн талаарх тайлан. ДЭМБ, 2009
14. WHO, Global tuberculosis report. Switzerland; 2012:1-42
15. Наранбат Н, Энхбаатар Л, Цэрэнбалжид Ц, Үлэмж И. Монгол улс дахь сүрьеэ өвчний тархалт, ойрын жилүүдийн хандлага. Монголын анагаах ухаан, 2002, 4(121)
16. ДЭМБ. Сүрьеэгийн байдал дэлхий дахинд тайлан. <http://www.who.int/whosis/mort/profiles/en/#M>
17. Оюунчимэг Ц. Энхтуяа С. ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасгуудад 2005-2009 онд нас барсан тохиолдлуудын судалгаа. Халдварт Өвчин Судлалын Монголын Сэтгүүл, 2010, 6(37)
18. Эрүүл мэндийн үзүүлэлт. ЗГХА-НЭМГ, 2010

- 19.Найдансүрэн Ц. Сүрьеэгийн бус эмнэлгийн дотрын тасгуудад уушигны сүрьеэ илрүүлэх. АУ-ны магистрын зэрэг горилж бичсэн нэг сэдэвт бүтээл Улаанбаатар Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль; 1997
- 20.Ганзаяа С. Монгол улсад бүртгэгдсэн сүрьеэ өвчний тархвар зүйд байгаль цаг уур, нийгмийн зарим хүчин зүйлсийн нөлөө. АУ-ны магистрын зэрэг горилж бичсэн нэг сэдэвт бүтээл Улаанбаатар Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль; 2008
- 21.Наранбат Н. Сүрьеэ өвчний анхан шатны тусламж үйлчилгээ Улаанбаатар, 2009. х.25, 21, 26, 14
- 22.American thoracic society. CDC, Infectious Disease Society of America. Diagnostic standards and classification of tuberculosis in adults and children. Am J Respir Crit Care Med 2000; 161:1376-95
- 23.Control of Communicable Diseases WHO. APHA, 2010;384-5.
- 24.Наранбат Н, Батхуяг Б. Сүрьеэ эдгэрдэг өвчин. Улаанбаатар. 2004 х.5
- 25.Gupta KB, Atreja A. Transmission of tuberculous infection and its control in health care facilities. NTI Bulletin 2006; 42:63 - 67
- 26.Нямдаваа П. Вакцин хэмээх ээлтэй үхэржин. Улаанбаатар, 2004 х.34-35
- 27.Лхагвасүрэн Ц. Монголын анагаах ухааны үндэсний нэвтэрхий толь. Боть II. Улаанбаатар 2012. х.1151-53
- 28.Global tuberculosis control WHO, 2011
- 29.ЗГХА-НЭМГ. Эрүүл мэндийн үзүүлэлт 2011; х.106
- 30.Наранбат Н, Батхуяг Б. Сүрьеэг илрүүлэх шинжилгээний сорьц цуглуулалт, тээвэрлэлт Улаанбаатар, 2005. х.15
- 31.Наранбат Н. Сүрьеэгийн халдвар хяналтын гарын авлага. Улаанбаатар. 2011 х.22
- 32.Буянхишиг Б. Сүрьеэг илрүүлэх шинжилгээний сорьц цуглуулалт, тээвэрлэлт Улаанбаатар. 2005; х.20, 21,24,25
- 33.Diagnostic Standards and classification of Tuberculosis in Adults and Children. Am J.Respir.Crit.Care Med. 2000; 161:1376-95
- 34.Historical Perspectives Centennial: Koch's Discovery of the Tubere Bacillus MMWR 1992; 31:121-3
- 35.Сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдамж. Улаанбаатар, 2010.х.9-10,39-40
- 36.Татсуро Ивасаки. Уушигны сүрьеэгийн рентген оношлогоо. Улаанбаатар. Сүрьеэ судлалын хүрээлэн; 1993 х.6-7, 31

37. Beck-Sague C, Dooley SW, Hutton MD, et al. Outbreak of multidrug-resistant *Mycobacterium tuberculosis* infections in a hospital: transmission to patients with HIV infection and staff. *JAMA* 2002;268:1280–6.
38. Наранбат Н. Сүрьеэгийн оношлогооны аргуудыг харьцуулан судалсан дүн. АУ-ны магистрын зэрэг горилж бичсэн тезис. Улаанбаатар, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль; 2001
39. Laniado-Laborín R, Cabrales-Vargas N. *Infect Control Hosp Epidemiol.* 2006; 27(5):449-52.
40. Kent A, Sepkowitz, Leon Eisenberg. Occupational deaths among healthcare workers. *Emerg Infect Dis.* 2005; 11:1003-08
41. Catanzaro A. Nosocomial tuberculosis. *Am Rev Respir Dis* 2002;125:559–62.
42. Ehrenkranz NJ, Kicklighter JL. Tuberculosis outbreak in a general hospital: evidence of air-borne spread of infection. *Ann Intern Med* 2002;77:377–82.
43. Hutton MD, Stead WW, Cauthen GM, et al. Nosocomial transmission of tuberculosis associated with a draining tuberculous abscess. *J Infect Dis* 2009;161:286–95.
44. Kantor HS, Poblete R, Pusateri SL. Nosocomial transmission of tuberculosis from unsuspected disease. *Am J Med* 1998;84:833–8.
45. Lundgren R, Norrman E, Asberg I. Tuberculous infection transmitted at autopsy. *Tubere* 1997;68:147–50.
46. CDC. *Mycobacterium tuberculosis* transmission in a health clinic—Florida, 2008. *MMWR* 2009;38:256–8,263–4.
47. Edlin BR, Tokars JL, Grieco MH, et al. An outbreak of multidrug-resistant tuberculosis among hospitalized patients with the acquired immunodeficiency syndrome. *N Engl J Med* 2002;326:1514–21.
48. Drug resistant tuberculosis: etiology, management and prevention. *Semin Respir Infect* 1994 Jun;9(2):104-12.
49. ЭМЯ. Сүрьеэгийн оношлогоо эмчилгээнд төр хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх нь. Улаанбаатар 2009. х.8
50. Laniado-Laborín R, Cabrales-Vargas N. Tuberculosis in healthcare workers at a general hospital in Mexico. *Infect Control Hosp Epidemiol.* 2006 May;27(5):449-52.
51. Drobniewski F, Balabanova Y, Zakamova E, Nikolayevskyy V, Fedorin I. Rates of latent tuberculosis in health care staff in Russia. *PLoS Med.* 2007;4(2): 55

52. Latent tuberculosis infection among health care workers at a general hospital in Santiago de Cuba. Borroto S; Gomez D; Díaz D; Marthnez Y; Ferrer A.I. et al. The International Journal of Tuberculosis and Lung Disease, 2011;11:1510-15
53. Incidence of tuberculosis among health care workers at a private university hospital in South Korea. Jo KW, Woo JH, Hong Y, Choi CM, Oh YM, Lee SD et al. Med J Aust. 2001;174(11):569-73.
54. CDC. The role of BCG vaccine in the Prevention and Control of Tuberculosis in the United States A Joint Statement by the Advisory Council for the Elimination of Tuberculosis and the Advisory Committee on Immunization Practices. MMWR 1996;45(RR-4):1-18
55. Assessing the risk of tuberculosis infection among healthcare workers: the Melbourne Mantoux Study. Melbourne Mantoux Study Group. Stuart RL, Bennett NJ, Forbes AB, Grayson ML
56. Prevalence and risk factors of latent tuberculosis infection among health care workers in Malaysia. Rafiza S, Rampal KG, Tahir A
57. Энхтамир П, Баатархүү О. Наранбат Н, Янжиндулам П, Энхтуяа С нар. Сүрьеэтай өвтөнүүдэд дархлаа зүгшрүүлэх эмчилгээ хийсэн дүн. Монголын анагаах ухаан, 2009, 2(148)
58. “Сүрьеэгийн үйлчилгээний нөхцөл байдлын үнэлгээ” судалгааны тайлан, Дэлхийн Зөн Монгол, УБ, 2006 он
59. Эрдэнэчимэг Э, Наранзул Д, Нарансүх Д, Мягмарчулуун С, Энхжаргал Г, Цолмон Ч, Цэвэгдорж Ц, Оюунтогос Л. Сүрьеэ Өвчний Талаарх Эмнэлгийн Ажилтны Мэдлэг, Дадал, Хандлагыг Судалгаа. Монголын Анагаах Ухаан, 2010; 3(151)
60. Наранзул Д. Эмч сувилагчийн дундах сүрьеэгийн халдварлалт, өвчлөл, эрсдэлт хүчин зүйлийн судалгаа. АУ-ны докторын зэрэг горилсон бүтээл. ЭМШУИС, 2013.